



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 2/04

Арвайхээр

Асран хамгаалагч тогтоох
тухай

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулийн 71.1.1, 72.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүсэлт ирүүлсний дагуу 10 дугаар багийн иргэн Эрдэнэтөгс овогтой Ган-Очирын асран хамгаалагчаар Наранцэцэг овогтой Мөнх-Эрдэнийг, 9 дүгээр багийн иргэн Цэрэндулам овогтой Лүндээжанцангийн асран хамгаалагчаар Жимээ овогтой Лхагважаргалыг тус тус тогтоосугай.

2. Асрамж дэмжлэгтээ байгаа хүнийг хоол хүнс, орон байраар хангах эрх ашиг сонирхлыг нь хамгаалах мөнгөн хөрөнгө үнэт зүйл, үнэт цаас бусад баримт бичгийг банкинд хадгалуулах, үл хөдлөх хөрөнгө, мал банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрсдөд нь зориулан зарцуулж, хүлээсэн үүргийнхээ талаар сумын Засаг даргад жил бүр тайлагнаж байхыг асран хамгаалагчид үүрэг болгосугай.

3. Асрамж дэмжлэгт байгаа хүнд хувийн хэрэг нээж асран хамгаалагчтай гэрээ байгуулж биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сум хариуцсан Улсын бүртгэгч /Г.Шагдарсүрэн/-д даалгасугай.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ



14 0007